



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 296

Улаанбаатар хот

Дуудлагын худалдааг дахин зохион байгуулах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 268 дугаар тогтоолын 4.3, 4.4, 269 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хархорум музейн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 12,225,000.00 (арван хоёр сая хоёр зуун хорин таван мянган) төгрөгийн балансын үнэ бүхий автомашины нээлттэй дуудлагын худалдааг (3 дахь) дахин зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баярсайхан, Хархорум музейн захирал Л.Шинэбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу Ажлын хэсэг байгуулан зохион байгуулах;

2.2.Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 4 дүгээр улиралд багтаан мэдээ, тайлангийн баталсан маягтаар ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГ

А.АРИУНБОЛД


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА



0000600

Төрийн өмчийн бодлого, зохицуулалт
 2019 оны 07 дугаар сарын 22 ны өдөр
 296 дугаар тогтоолын хавсралт



Хархорум музейн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах
 автомашины жагсаалт

Машины марк, улсын дугаар, зориулалт, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагд сан элэгдэл	Үлдэгдэл өртөг	ТӨБЗГ-ын 2018 оны 463 дугаар тогтоолоор тогтоосон доод үнэ	Худ үн
Ли Делика , 93, микробус, 8W0015283	1995/2004	275,066	12,225,000.00	12,225,000.00	-	1,200,000.00	
			/төгрөг/				
ИЙТ ДҮН			12,225,000.00	12,225,000.00	-	-	
			(арван хоёр сая хоёр зуун хорин таван мянган)			(нэг сая хоёр зуун мянган)	(зу